

**БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР**



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сайхан сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: БУА-2026/10/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Булган аймаг
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: Д.Батцогт
Утас: 70342580 Цахим хаяг: Battsogtd@audit.gov.mn
Аудитын менежер: Ж.Энхцоодол
Утас: 70342495 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn
Аудитор: Б.Энхтөр
Утас: 70342495 Цахим хаяг: ganbaatarz@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,
63082, Утас/Факс:7034-2580
Цахим шуудан:bulgan@audit.gov.mn

2026-02-24 № 233

танай _____ ны № _____ т

САЙХАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Ц.ИЧИНХОРЛОО ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сайхан сумын ЗДТГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Сайхан сумын ЗДТГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

- Тайлант онд 3,396.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 67.7 сая төгрөгийн бараа материалын жилийн эцсийн тооллого хийгээгүй,
- Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн тоног төхөөрөмж, зэвсэглэмжийн засвар үйлчилгээг хийхэд 2.0 сая төгрөгийг зарцуулсан ч санхүүжилтийг давхардуулан олгосон,
- Тайлан онд шинэ жилийн баяраар торт, оргилуун дарс, бэлэг 2,357.0 мянган төгрөг, аймгийн ажлын хэсгийн бүрэлдэхүүнд 770.0 мянган төгрөгөөр айраг нийт 3,127.0 мянган төгрөгийн зарцуулсан,
- Тайлан онд ажил хавсран гүйцэтгүүлсэн 2 албан хаагчдад сарын цалингийн зөрүүг олгох бус 40 хувиар тооцон 2.8 сая төгрөгийг илүү олгосон,
- Сумын 100 жилийн ойн баяр наадмын хүрээнд 3 гэрт гэрийн бүрээс гадар, дотор, ширээний бүтээлэг 30, цагаан хэрэгсэл 23 ширхэгийг 3.9 сая төгрөгөөр авсан ч өглөгөөр бүртгээгүй, тооцоо хийх баримтгүй 2025 онд

6326050296

мөнгийг шилжүүлсэн зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитын шийдвэрийг хэрэгжилтээс 2023 оны 1.0 сая төгрөгийн 1 төлбөрийн акт, 2024 оны 8.5 сая төгрөгийн 1 төлбөрийн акт нийт 9.5 сая төгрөгийн 2 төлбөрийг актыг барагдуулаагүй байна.

Аудитын гол асуудал

Сайхан сумын Засаг даргын тамгын газар нь Хөрөнгийн тооллого хийх ажлын хэсгийг томилсон боловч жилийн эцсийн үндсэн хөрөнгө болон бараа материалын тооллогыг хугацаанд нь чанартай хийж гүйцэтгээгүй байна.

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

АДБОУС 2706 10-д зааснаар хууль тогтоомжоор хориглоогүй, аудитын тайланд заавал мэдээлэх аудитын гол асуудал гэж тодорхойлоогүй, тухайлбал аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүссэн тухай, санхүүгийн тайлангийн аудит, аудитын тайлантай холбоотой аудиторын хүлээх үүрэг хариуцлагын тухай дэлгэрэнгүй тайлбар өгөхөөр хууль тогтоомжоор шаардсан мэдээллийг тусгана.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Д.БАТЦОГТ



Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

	Үзүүлэлт	2024.12.31	2025.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	109.4	89.1
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2,167.6	2,444.4
	Нийт хөрөнгийн дүн	2,276.9	2,533.5
	Нийт өр төлбөрийн дүн	2.4	2.4
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,274.5	2,531.1
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,276,926.3	2,533,512.8
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	1,792,806.2	1,565,860.1
	Үйл ажиллагааны зардлын дүн	1,473,579.0	1,309,273.6
	Үйл ажиллагааны үр дүн	319,227.1	256,586.5
	Үйл ажиллагааны бус үр дүн	2,250.1	-
	Үйл ажиллагааны нийт үр дүн	316,977.0	256,586.5
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,274,526.26	2,274,526.26
	Тайлант оны үр дүн	-	256,586.51
	Эцсийн үлдэгдэл	-	2,531,112.77
Мөнгөн гүйлгээний тайлан			
	0	0	0
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	1,197,439	1,179,180
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	1,167,349	1,127,014
	Үйл ажиллагааны ЦМГ	30,090	52,165
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	-30,090	-52,165
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	30,090	52,165
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	0	0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	0
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	1,183,549	1,114,473
	Урсгал зардал	1,183,549	1,114,473
	Хөрөнгийн зардал	0	0
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	204,677.10	167,259.10
	Улсын төсвөөс санхүүжих	978,871.60	947,213.95
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	0	0

Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 3,603.9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 8.4 сая төгрөгийн 1 алдааг залруулж, 106.9 сая төгрөгийн 1 зөвлөмж, 3,473.6 сая төгрөгийн 2 албан шаардлага, 15.1 сая төгрөгийн 8 төлбөрийн акт тогтоосон.

5.1 Төлбөрийн акт

- ✓ Тайлант онд 1,053,100.00 (нэг сая тавин гурван мянга нэг зуу) төгрөгийн шатахууныг анхан шатны баримтгүй зарцуулсан,
- ✓ Тайлант онд Засаг даргад 533,500.00 (таван зуун гучин гурван мянга таван зуу) төгрөгөөр нормын хувцас худалдан авсан,
- ✓ Тайлант онд тооцоо нийлсэн актгүй өглөгөөр бүртгээгүй өмнөх оны албан томилолтын зардалд 920,000.00 (есөн зуун хорин мянган) төгрөгийг зарцуулсан,
- ✓ Сумын 100 жилийн ойн баяр наадмын хүрээнд 3 гэрийн бүрээс гадар, дотор, ширээний бүтээлэг 30, цагаан хэрэгсэл 23 ширхэг нийт 3,895,000.00 (гурван

сая найман зуун ерэн таван мянган) төгрөгийг өмнөх онд өглөгөөр бүртгээгүй, тооцоо хийх баримтгүй 2025 онд мөнгийг шилжүүлсэн,

- ✓ Тайлант онд гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн тоног төхөөрөмж, зэвсэглэмжийн засвар үйлчилгээг хийхэд 2,000,000.00 (хоёр сая) төгрөгийн санхүүжилтийг давхардуулан илүү олгосон,
- ✓ Тайлант онд Засаг дарга шинэ жилийн арга хэмжээнд 2,357,000.00 (хоёр сая гурван зуун тавин долоо мянган) төгрөгөөр торт, шампанск, бэлэг, аймгийн ажлын хэсгийн бүрэлдэхүүнд 770,000.00 (долоон зуун далан мянган) төгрөгийн айраг нийт 3,127,000.0 (гурван сая нэг зуун хорин долоон мянган) төгрөгөөр бэлэг дурсгал болон согтууруулах ундаа худалдан авсан,
- ✓ ЗДТГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч байгаль орчны улсын байцаагч, мөн санхүү албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч мал зүйч албан тушаалтнаар ажилладаг 2 албан хаагчид сарын үндсэн цалингийн зөрүүгээр тооцож олгох байтал 40 хувиар тооцож 2,766,000.0 (хоёр сая долоон зуун жаран зургаан мянга) төгрөгийг илүү олгосон байна.
- ✓ Засаг даргын тамгын газрын няравт 9, 10, 11 дүгээр сард ур чадварын нэмэгдлийг 50 хувиар бодож 828,800.00 (Найман зуун хорин найман мянга найман зуун) төгрөгийг илүү бодож олгосон

5.2 Албан шаардлага

- ✓ Тайлант онд 3,396,463,630.53 (гурван тэрбум гурван зуун ерэн зургаан сая дөрвөн зуун жаран гурван мянга зургаан зуун гучин төгрөг тавин гурав) мөнгөний үндсэн хөрөнгө, 67,658,081.20 (жаран долоон сая зургаан зуун тавин найман мянга наян нэгэн төгрөг хорь) мөнгөний бараа материал нийт 3,464,121,711.73 (гурван тэрбум дөрвөн зуун жаран дөрвөн мянга нэг зуун хорин нэгэн мянга долоон зуун арван нэгэн төгрөг далан гурав) мөнгөний хөрөнгөд жилийн эцсийн тооллого хийгээгүй,
- ✓ Сайхан сумын Засаг даргын тамгын газрын дарга, нягтлан бодогч нар албан тушаалаас чөлөөлөгдөн, 2025 оны 10 дугаар сараас түр орлон гүйцэтгэгч томилогдсон гэх шалтгаанаар өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитын шийдвэрийн хэрэгжилт болох 2023 оны 1,000,000.00 (нэг сая) төгрөгийн 1 төлбөрийн акт, 2024 оны 8,509,554.00 (найман сая таван зуун есөн мянга таван зуун тавин дөрөв) төгрөгийн 1 төлбөрийн акт, нийт 9,509,554.00 (есөн сая таван зуун есөн мянга таван зуун тавин дөрөв) төгрөгийн 2 төлбөрийн актыг биелэлтийг одоог хүртэл шийдвэрлээгүй байна.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:1 Үндсэн хөрөнгийн тээврийн хэрэгслийн дансанд бүртгэлтэй 4 нэр төрлийн 100,894.8, машин тоног төхөөрөмжийн дансанд бүртгэлтэй 3 нэр төрлийн 3,821.2, тавилга эд хогшлын дансанд бүртгэлтэй 20 нэр төрлийн 5,952.8 нийт 27 нэр төрлийн 106,847.7 мянган төгрөгийн элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгүүдийг дахин үнэлээгүй

Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийн үнэ тогтоох, шинж чанараас хамаарч акталж устгах зэрэг ажлыг зохион байгуулан ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/Мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант онд жилийн эцсийн санхүүгийн байдлын тайланд нийт хөрөнгийн дүнгийн эцсийн үлдэгдэл 2,532,948.1 мянган төгрөг өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүнгийн эцсийн үлдэгдэл 2,524,558.5 мянган төгрөгөөр илэрхийлэгдэж 8,389.6 мянган төгрөгөөр байдлын тайлангийн эцсийн үлдэгдэл зөрүүтэй.	1	8,389.6			1	8,389.6	1	8,389.6				
Дүн	1	8,389.6			1	8,389.6	1	8,389.6				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Тоо	Дүн	Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Үндсэн хөрөнгийн	1	106,847.7					1	106,847.7				

тээврийн хэрэгслийн дансанд бүртгэлтэй 4 нэр төрлийн 100,894.8, машин тоног төхөөрөмжийн дансанд бүртгэлтэй 3 нэр төрлийн 3,821.2, тавилга эд хогшлын дансанд бүртгэлтэй 20 нэр төрлийн 5,952.8 нийт 27 нэр төрлийн 106,847.7 мянган төгрөгийн элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгүүдийг дахин үнэлээгүй												
Тайлант онд шатахууны зардлаас 1,053.1 мянган төгрөгийн анхан шатны баримтгүй зарцуулсан	1	1,053.1	1	1,053.1								
Сумын 100 жилийн ойн баяр наадмын хүрээнд 3 гэрт гэрийн бүрээс гадар, дотор, ширээний бүтээлэг 30, цагаан хэрэгсэл 23 ширхгийг авсан ч өглөгөөр бүртгээгүй, тооцоо хийх баримтгүй 2025 онд мөнгийг шилжүүлсэн	1	3,895.0	1	3,895.0								
Тайлант онд албан томилолтын зардлаас 2024 оны жилийн эцсээр өглөгөөр бүртгээгүй 9 албан хаагчийн 720.0, сургалтанд хамрагдаагүй 2 албан хаагчид 200.0 нийт	1	920.0	1	920.0								

920.0 мянган төгрөгийн томилолтыг олгосон.												
Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн тоног төхөөрөмж, зэвсэглэмжийн засвар үйлчилгээг хийхэд 2,000.0 мянган төгрөгийг зарцуулсан ч санхүүжилтийг давхардуулан олгосон.	1	2,000.0	1	2,000.0								
Тайлан онд шинэ жилийн баяраар торт, шампансик, бэлэг авсан 2,357.0 мянган төгрөг, аймгийн ажлын хэсгийн бүрэлдэхүүнд 770.0 мянган төгрөгөөр айраг нийт 3,127.0 мянган төгрөгийг зарцуулсан.	1	3,127.0	1	3,127.0								
Тайлант онд Засаг даргад 533.5 мянган төгрөгийн норм хувцас худалдан авсан төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчсөн.	1	533.5	1	533.5								
Тайлан онд ажил хавсран гүйцэтгүүлсэн 2 албан хаагчид сарын цалингийн зөрүүг олгох бус 40 хувиар тооцон 2,766.0 мянган төгрөгийг илүү олгосон.	1	2,766.0	1	2,766.0								
Тайлан онд няравт 9, 10, 11 сард ур чадварыг 50 хувиар бодож 828.8 мянган төгрөгийг илүү бодож олгосон.	1	828.8	1	828.8								
Тайлант онд 3,396,463.6 мянган	1	3,464,121.7			1	3,464,121.7						

төгрөгийн үндсэн хөрөнгө, 67,658.1 мянган төгрөгийн бараа материалын жилийн эцсийн тооллого хийгээгүй.												
Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитын шийдвэрийг хэрэгжилтээс 2023 оны 1,000.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 2024 оны 8,509.6 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт нийт 9,509.6 мянган төгрөгийн 2 төлбөрийг актыг барагдуулаагүй байна.	1	9,509.5			1	9,509.5						
Дүн	11	3,595,602.3	8	15,123.4	2	3,473,631.3	1	106,847.7				